



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/202

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9, 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Булган Хан, Булган Хангай дэвжээний бөхчүүдийг аймгийн төвийн бөхийн спортоор хичээллэдэг хүүхэд, залуучуудтай хамтарсан бэлтгэл хийлгэх, өв уламжлалаа хадгалах, сурталчлахад зориулж 11,300,000 (арван нэгэн сая гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын хуулиар олгогдсон зарим чиг үүргийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

